



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/227

Мөрөн

Дэмжлэг үзүүлэх тухай

Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 8.3.1, Засаг захиргаа, нутаг дэсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" дахь заалт, Аймгийн Мал хамгаалах сангийн удирдах зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 04-ний хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Рашаант сум нь зудын байдлын үнэлгээгээр "Цагаан зудтай" ангилалд хамрагдаж байгаа тул мал сүргийг байгалийн болзошгүй эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор 1000 боодол буюу 5000.000 /Таван сая төгрөг/-ний өвсийг Рашаант суманд буцалтгүй тусламж хэлбэрээр олгосугай.

2. Дээрх тусламжаар олгогдож байгаа өвс, тэжээлийг данс бүртгэлээс хасаж тооцохыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч /Н.Азаяа/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД